

ЭНЭ МЭДЭЭГ ОДООНООС АШИГЛАЖ БОЛНО.

Хэвлэлийн мэдээ

№. 14-06

2014 оны 6 дугаар сарын 27-ны өдөр

2014 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн /Бямба гараг/ 11:00-19:00 цагийн хооронд тус Элчин сайдын яам нь Улаанбаатар хотын АСА циркт “Японы Поп соёлын өдөрлөг” арга хэмжээг зохион байгуулна.

Тус арга хэмжээг сүүлийн үед Монголд нэн алдартай болоод буй Японы *Анимэ* болон *Манга*, *Косплэй* зэргийг сонирхогчдоос бүрдсэн Японы соёлыг сонирхогч залуусын холбоотой хамтран зохион байгуулж байгаа бөгөөд төрөл бүрийн тайзны хөтөлбөр /Мэйд-батлер нарын бүжгийн үзүүлбэр, Анимэ дууны тэмцээн, Косплэй тэмцээн, Тата-тунгаа тэмцээн, Зургийн тэмцээн зэрэг/ болон үзүүлбэрийн булангууд /Дуу хөгжмийн булан, Мэйд кафе, Поп соёлын булан, Зураг авахуулах булан зэрэг/-ыг ажиллуулах болно. Мөн Японоос дуучин-хөгжмийн зохиолч Кио САКАЙ болон гитарчин Кацүхико САТО нар тусгай зочноор оролцоно.

Энэ арга хэмжээнд Япон улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Аялал Жуулчлалын Газраас Монголд анх удаа “Visit Japan Fair” буюу Японд аялах өдөрлөгийн буланг нээн ажиллуулахаар төлөвлөөд байна.

ЯПОН УЛСААС МОНГОЛ УЛСАД СУУГАА ЭЛЧИН САЙДЫН ЯАМ

ЛАВЛАХ УТАС:320777